



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/35/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.14 № 70

танай _____ -ны № _____ -т

ХЭРЛЭН СУМЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БАТСҮХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519550



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Батсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн бараа материалын анхан шатны баримтыг хөтлөх талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх”-д оршино.

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшүүлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 1-р сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд 10 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,382,856.0 мянган төгрөгөөс тооцон 27,717.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 32,482.2 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,982,2. мянган төгрөгөөр буюу 3,7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,106,9		-1,106,9
Урьдчилгаа			
Бараа материал	150,778.3	187,994.0	37,215.7
Үндсэн хөрөнгө	1,944,921.6	1,947,783.4	2,861.8
Элэгдэл	-406,346.9	-507,299.8	-100,952.9
Нийт хөрөнгө	1,690,459.9	1,628,477.7	-61,982.2
Өр төлбөр	1,106.9		-1,106.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,689,353.0	1,628,477.7	-60,875.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,690,459.9	1,628,477.7	-61,982.2

Авлага, өглөгийн дансны үлдэгдэл 1,106.9 мянган төгрөгөөр буурсан нь ХХАОАТ-ын хөнгөлөлтийг дутуу тооцон авлага үүсгэснийг тайлант онд суутган тооцож хүмүүст буцаан олгосонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 37,215.7 мянган төгрөгөөр өссөн нь БСШУСЯ-аас 32,229.9 мянган төгрөгийн сурах бичиг, 24700,5 мянган төгрөгийн сургалтын үзүүлэн тараах материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 4985,8 мянган төгрөгийн сургалтын хэрэгдэхүүн худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,8091.0 мянган төгрөгөөр буурсан нь он удаан жил ашиглаж техникийн хоцрогдолд орсон цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг Хэрлэн сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 10-ны А/49 тоот тогтоолоор данснаас хассанаас шалтгаалжээ.

Хэрлэн сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 10-ны А/49 тогтоолоор 12,009.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө 1,474.0 буурсан нь Хэрлэн сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 10-ны А/49 тогтоолоор цаашид ашиглах, сайжруулалт хийх боломжгүй техникийн хоцрогдолд орсон 1,474.0 мянган төгрөгийн программыг данснаас хассантай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,628,477.7 мянган төгрөг болж 60,875.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны ашиг алдагдал 60,875.4 мянган төгрөг ба 2018 онд дахин үнэлсэн барилга байгууламжийн элэгдэл энэ оноос эхлэн элэгдэл тооцогдон тухайн оны хөрөнгийн элэгдэл өссөнөөс шалтгаалжээ.



Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын 540.3 мянган төгрөгийн бууралт нь дахин үнэлсэн хөрөнгө данснаас хассантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,491,305.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,491,305.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,440,379.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 50,926.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1491305.9 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь тайлант онд төсвийг бүрэн зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар хөрөнгө аваагүй бөгөөд дээд шатны төсвийн захирагчаас 26200,5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,113.9 мянган төгрөг, нийт 27,314.4 мянган төгрөгөөр нэмэлт төсөв бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 25,334.4 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 1980,0 мянган төгрөг нийт 27314,4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 19 эрсдэл тодорхойлж нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 54,700.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 54,200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 54,700.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 54,200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд хийсэн 54,200.0 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2017 оны 349 дүгээр тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв



2. Үндсэн хөрөнгө, бараа материалын орлого зарлагын гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад түлш шатах тослох материалын дансанд 500.0 мянган төгрөгийн шатахууныг нөөцөлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авалтын е баримтыг баримтад хавсарган, төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллахад анхаарах шаардлагатай.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын 1 дүгээр сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалин, хөдөлмөрийн хөлсний талаар

1.1. Илрүүлэлт: Тэтгэвэрт гарсан хүнийг Төрийн албаны тухай хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээ дахин хийлгүй ажиллуулсан байна.

1.2. Эрсдэл: Хууль тогтоомж хэрэгжихгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж: Төрийн албаны тухай хуулийг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	151 885 219,00	187 993 995,00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00,00	00,00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00,00	00,00
33	АВЛАГА	1 106 908,00	00,00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1 106 908,00	00,00
35	БАРАА МАТЕРИАЛ	150 778 311,00	187 993 995,00
351	Түүхий эд материал	00,00	00,00
354	Хангамжийн материал	150 778 311,00	187 993 995,00
35410	Бичиг хэргийн материал	990 900,00	1 220 400,00
35420	Аж ахуйн материал	536 760,00	375 570,00
35430	Сэлбэг хэрэгсэл	00,00	00,00
35440	Түлш, шатах тослох материал	00,00	500 000,00
35450	Барилгын засварын материал	00,00	00,00
35460	Хүнсний материал	00,00	00,00
35470	Бусад хангамжийн материал	149 250 651,00	185 898 025,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1 538 574 700,61	1 440 483 660,57
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00,00	00,00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1 538 574 700,61	1 440 483 660,57
391	Газар	00,00	00,00
392	Биет хөрөнгө	1 273 124 700,61	1 175 033 660,57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 118 748 077,00	1 118 748 077,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00,00	-58 590 621,96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00,00	00,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00,00	00,00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	334 667 188,31	332 829 979,31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-259 774 857,89	-286 512 279,56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76 606 322,00	76 216 794,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-60 055 829,27	-62 269 088,76
39214	Бусад үндсэн хөрөнгө	147 536 000,00	154 098 600,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-84 602 199,54	-99 487 799,46
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00,00	00,00
39217	Ном	00,00	00,00
393	Биет бус хөрөнгө	265 450 000,00	265 450 000,00
39301	Програм хангамж	1 914 027,00	440 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1 914 027,00	-440 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	265 450 000,00	265 450 000,00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00,00	00,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1 690 459 919,61	1 628 477 655,57
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1 106 908,00	00,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1 106 908,00	00,00
413	Өглөг	1 106 908,00	00,00
4136	Бусад өглөг	1 106 908,00	00,00
41361	Байгууллагад төлөх өглөг	00,00	00,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1 106 908,00	00,00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	00,00	00,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1 689 353 011,61	1 628 477 655,57
51	Засгийн газрын хувь оролцоо	1 689 353 011,61	1 628 477 655,57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	937 080 377,99	937 080 377,99
51101	Өмч: - төрийн	671 630 377,99	671 630 377,99
51102	- хувийн	00,00	00,00
51103	- хувьцаат	265 450 000,00	265 450 000,00
51104	Халаасны хувьцаа	00,00	00,00
51105	Нэмж төлөгдсөн капитал	00,00	00,00



Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51106	Эздийн өмчийн бусад хэсэг	00,00	00,00
512	Хуримтлагдсан үр дүн	6 180 356,25	-54 154 736,45
51210	Өмнөх үеийн үр дүн	6 180 356,25	6 720 619,59
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	-60 875 356,04
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00,00	00,00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	746 092 277,37	745 552 014,03
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	00,00	00,00
51600	Нөөцийн сан	00,00	00,00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1 690 459 919,61	1 628 477 655,57

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1 525 822 753,00	1 563 237 331,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00,00	00,00
110	Орлогын албан татвар	00,00	00,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	249 764 619,00	95 543 831,00
120	Нийтлэг татварын бус орлого	19 477 432,00	32 506 931,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19 477 432,00	32 506 931,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19 477 432,00	32 506 931,00
121	Хөрөнгийн орлого	230 287 187,00	12 110 100,00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	230 287 187,00	12 110 100,00
121002	Өмч хувьчлалын орлого	00,00	00,00
122	Тусламжийн орлого	00,00	50 926 800,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6 493 034,00	27 314 400,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00,00	00,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1 269 565 100,00	1 440 379 100,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6 493 034,00	27 314 400,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00,00	1 500 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5 256 334,00	24 700 500,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1 236 700,00	1 113 900,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1 385 856 090,15	1 624 014 975,87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 385 856 090,15	1 624 014 975,87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 228 112 290,15	1 528 451 932,87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	924 893 038,00	1 167 640 877,00
210101	Үндсэн цалин	700 378 437,00	841 503 477,00
210102	Нэмэгдэл	158 200 000,00	211 648 478,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00,00	00,00
210104	Урамшуулал	66 314 601,00	114 488 922,00
210105	Гэрээт ажлын хөлс	00,00	00,00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111 185 197,00	145 955 323,00
210201	Тэтгэврийн даатгал	74 124 097,00	99 249 623,00
210202	Тэтгэмжийн даатгал	8 680 400,00	11 676 500,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7 997 200,00	9 341 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1 853 100,00	2 335 200,00
210205	Эрүүл мэндийн даатгал	18 530 400,00	23 352 800,00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47 199 900,00	47 351 657,00
210301	Гэрэл, цахилгаан	12 389 000,00	12 943 021,00
210302	Түлш, халаалт	21 582 674,00	23 625 464,00
210303	Цэвэр, бохир ус	13 228 226,00	10 783 172,00
210304	Байрны түрээс	00,00	00,00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00



Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	31 023 744,40	17 391 060,00
210401	Бичиг хэрэг	1 538 390,00	1 866 500,00
210402	Тээвэр, шатахуун	2 160 300,00	1 289 031,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 307 930,00	1 779 971,00
210404	Ном, хэвлэл	20 807 474,40	596 560,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	300 300,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5 209 650,00	11 558 698,00
2105	Нормативт зардал	1 795 500,00	3 404 200,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800 000,00	800 000,00
210502	Хоол, хүнс	00,00	00,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	995 500,00	2 604 200,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4 000 000,00	3 000 000,00
210604	Урсгал засвар	4 000 000,00	3 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	1 094 000,00	4 910 000,00
210701	Гадаад албан томилолт	00,00	00,00
210702	Дотоод албан томилолт	1 094 000,00	4 910 000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00,00	00,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 380 000,00	1 379 900,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 200 000,00	1 199 900,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105 540 910,75	137 418 915,87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	1 000 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9 894 725,00	22 080 587,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95 146 185,75	114 338 328,87
210904	Найдваргүй авлагын алдагдал	00,00	00,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157 743 800,00	95 563 043,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	157 629 315,00	94 987 900,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	88 531 215,00	92 187 900,00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	00,00	00,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38 918 900,00	00,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29 279 200,00	00,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900 000,00	2 800 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	114 485,00	575 143,00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00,00	00,00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00,00	00,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	114 485,00	575 143,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	139 966 662,85	-60 777 644,87
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00,00	00,00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00,00	97 711,17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00,00	97 711,17
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00,00	-97 711,17
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	139 966 662,85	-60 875 356,04

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1 276 058 134,00	1 518 620 300,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00,00	00,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00,00	50 926 800,00
120	Нийтлэг татварын бус орлого	00,00	50 926 800,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 276 058 134,00	1 467 693 500,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00,00	00,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1 269 565 100,00	1 440 379 100,00



Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00,00	00,00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	00,00	00,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6 493 034,00	27 314 400,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00,00	1 500 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5 256 334,00	24 700 500,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1 236 700,00	1 113 900,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1 276 058 134,00	1 518 620 300,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 276 058 134,00	1 518 620 300,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 118 314 334,00	1 423 057 257,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	926 453 100,00	1 167 641 000,00
210101	Үндсэн цалин	701 938 499,00	841 503 600,00
210102	Нэмэгдэл	158 200 000,00	211 648 478,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00,00	00,00
210104	Урамшуулал	66 314 601,00	114 488 922,00
210105	Гэрээт ажлын хөлс	00,00	00,00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111 183 600,00	145 955 200,00
210201	Тэтгэврийн даатгал	74 122 500,00	99 249 500,00
210202	Тэтгэмжийн даатгал	8 680 400,00	11 676 500,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7 997 200,00	9 341 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1 853 100,00	2 335 200,00
210205	Эрүүл мэндийн даатгал	18 530 400,00	23 352 800,00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47 199 900,00	47 351 657,00
210301	Гэрэл, цахилгаан	12 389 000,00	12 943 021,00
210302	Түлш, халаалт	21 582 674,00	23 625 464,00
210303	Цэвэр, бохир ус	13 228 226,00	10 783 172,00
210304	Байрны түрээс	00,00	00,00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2104	Хангамж, бараа материалын зардал	9 936 900,00	22 791 500,00
210401	Бичиг хэрэг	1 537 990,00	2 443 300,00
210402	Тээвэр, шатахуун	1 660 300,00	1 789 031,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 307 930,00	1 860 971,00
210404	Ном, хэвлэл	1 009 500,00	3 899 960,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	300 300,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4 421 180,00	12 497 938,00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00,00	00,00
210408	Бараа материал акталсны зардал	00,00	00,00
2105	Нормативт зардал	2 300 000,00	1 600 000,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800 000,00	800 000,00
210502	Хоол, хүнс	00,00	00,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 500 000,00	800 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4 000 000,00	3 000 000,00
210604	Урсгал засвар	4 000 000,00	3 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	1 094 000,00	4 910 000,00
210701	Гадаад албан томилолт	00,00	00,00
210702	Дотоод албан томилолт	1 094 000,00	4 910 000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00,00	00,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 380 000,00	1 379 900,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 200 000,00	1 199 900,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14 766 834,00	28 428 000,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	1 000 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14 266 834,00	27 428 000,00



Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157 743 800,00	95 563 043,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	157 629 315,00	94 987 900,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	88 531 215,00	92 187 900,00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	00,00	00,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38 918 900,00	00,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29 279 200,00	00,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900 000,00	2 800 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	114 485,00	575 143,00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00,00	00,00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00,00	00,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	114 485,00	575 143,00
213304	Хөрөнгийн	00,00	00,00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00,00	00,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00,00	00,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00,00	00,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00,00	00,00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
14	Бусад эх үүсвэр	00,00	00,00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00	00,00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00	00,00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	00,00	00,00	00,00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	937 080 377,99	746 092 277,37	6 180 356,25	00,00	1 689 353 011,61
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	937 080 377,99	746 092 277,37	6 180 356,25	00,00	1 689 353 011,61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	540 263,34	00,00	540 263,34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	937 080 377,99	746 092 277,37	6 720 619,59	00,00	1 689 893 274,95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	-540 263,34	00,00	00,00	-540 263,34
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00	00,00



Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	-60 875 356,04	00,00	-60 875 356,04
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	937 080 377,99	745 552 014,03	-54 154 736,45	00,00	1 628 477 655,57

4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 269 565 100,00	1 269 565 100,00	1 491 305 900,00	1 490 730 757,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 269 565 100,00	1 269 565 100,00	1 491 305 900,00	1 490 730 757,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 112 821 400,00	1 112 821 400,00	1 397 118 000,00	1 396 542 857,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	926 531 600,00	926 531 600,00	1 167 641 000,00	1 167 641 000,00
210101	Үндсэн цалин	704 658 600,00	704 658 600,00	841 503 600,00	841 503 600,00
210102	Нэмэгдэл	158 200 000,00	158 200 000,00	210 874 600,00	211 648 478,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			00,00	00,00
210104	Урамшуулал	63 673 000,00	63 673 000,00	115 262 800,00	114 488 922,00
210105	Гэрээт ажлын хөлс	00,00	00,00	00,00	00,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111 183 600,00	111 183 600,00	145 955 200,00	145 955 200,00
210201	Тэтгэврийн даатгал	74 122 500,00	74 122 500,00	99 249 500,00	99 249 500,00
210202	Тэтгэмжийн даатгал	8 680 400,00	8 680 400,00	11 676 500,00	11 676 500,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7 997 200,00	7 997 200,00	9 341 200,00	9 341 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1 853 100,00	1 853 100,00	2 335 200,00	2 335 200,00
210205	Эрүүл мэндийн даатгал	18 530 400,00	18 530 400,00	23 352 800,00	23 352 800,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47 221 500,00	47 221 500,00	47 926 800,00	47 351 657,00
210301	Гэрэл, цахилгаан	12 310 600,00	12 310 600,00	12 600 000,00	12 943 021,00
210302	Түлш, халаалт	21 579 400,00	21 579 400,00	22 400 000,00	23 625 464,00
210303	Цэвэр, бохир ус	13 331 500,00	13 331 500,00	12 926 800,00	10 783 172,00
210304	Байрны түрээс	00,00	00,00	00,00	00,00
2104	Хангамж, бараа материалын зардал	8 704 700,00	8 704 700,00	17 415 000,00	17 415 000,00
210401	Бичиг хэрэг	1 300 000,00	1 300 000,00	2 523 400,00	2 223 300,00
210402	Тээвэр, шатахуун	1 390 000,00	1 390 000,00	2 325 900,00	1 249 031,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 714 700,00	1 714 700,00	1 329 100,00	360 971,00
210404	Ном, хэвлэл	800 000,00	800 000,00	1 113 300,00	783 460,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	00,00	756 900,00	300 300,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3 500 000,00	3 500 000,00	9 366 400,00	12 497 938,00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00,00	00,00	00,00	00,00
2105	Нормативт зардал	2 300 000,00	2 300 000,00	1 600 000,00	1 600 000,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800 000,00	800 000,00	800 000,00	800 000,00
210502	Хоол, хүнс	00,00	00,00	00,00	00,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 500 000,00	1 500 000,00	800 000,00	800 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4 000 000,00	4 000 000,00	3 000 000,00	3 000 000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00,00	00,00	00,00	00,00
210602	Тавилга	00,00	00,00	00,00	00,00



Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00,00	00,00	00,00	00,00
210604	Урсгал засвар	4 000 000,00	4 000 000,00	3 000 000,00	3 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	1 000 000,00	1 000 000,00	600 000,00	600 000,00
210701	Гадаад албан томилолт	00,00	00,00	00,00	00,00
210702	Дотоод албан томилолт	1 000 000,00	1 000 000,00	600 000,00	600 000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00,00	00,00	00,00	00,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 380 000,00	1 380 000,00	1 180 000,00	1 180 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 200 000,00	1 200 000,00	1 000 000,00	1 000 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10500000,00	10500000,00	11800000,00	11800000,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	500 000,00	500 000,00	500 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10 000 000,00	10 000 000,00	11 300 000,00	11 300 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156 743 700,00	156 743 700,00	94187900,00	94187900,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00,00	00,00	00,00	00,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00,00	00,00	00,00	00,00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00,00	00,00	00,00	00,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	156 743 700,00	156 743 700,00	94 187 900,00	94 187 900,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	88 545 600,00	88 545 600,00	92 187 900,00	92 187 900,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38 918 900,00	38 918 900,00	00,00	00,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29 279 200,00	29 279 200,00	00,00	00,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00,00	00,00	2 000 000,00	2 000 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00,00	00,00	00,00	00,00
2200	Дотоод эх үүсвэрээр	00,00	00,00	00,00	00,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 269 565 100,00	1 269 565 100,00	1 491 305 900,00	1 491 305 900,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1 269 565 100,00	1 269 565 100,00	1 440 379 100,00	1 440 379 100,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1 269 565 100,00	1 269 565 100,00	1 440 379 100,00	1 440 379 100,00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00,00	00,00	00,00	00,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00,00	00,00	50 926 800,00	50 926 800,00
132001	Орон нутгийн төсвөөс	00,00	00,00	50 926 800,00	50 926 800,00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00,00	00,00	00,00	00,00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01,00	01,00	01,00	01,00
610001	Төсвийн байгууллага	00,00	00,00	00,00	00,00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00,00	00,00	00,00	00,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	102,00	102,00	102,00	102,00
620001	Удирдах ажилтан	01,00	01,00	01,00	01,00
620002	Гүйцэтгэх ажилтан	91,00	91,00	91,00	91,00
620003	Үйлчлэх ажилтан	10,00	10,00	10,00	10,00
620004	Гэрээт ажилтан	00,00	00,00	00,00	00,00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	00,00	00,00	00,00	00,00



Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	00,00	00,00	00,00	00,00
630001	Төрийн өмчит ЕБС	1 968,00	1 968,00	2 037,00	2 037,00